



ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2013 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 4/135

Улиастай

Дэд зөвлөл байгуулах тухай

Монгол улсын Засгийн газрын 2012 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах зарим арга хэмжээний тухай" 222 дугаар тогтоолын 11 дүгээр зүйлийн 11.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий компани болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны талаар иргэдэд нээлттэй мэдээллэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын дэд зөвлөл"-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч

Б.Нямдорж

Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд

Д.Бат-Ундраа

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга

П.Батсайхан

Мэргэжлийн хяналтын газрын дарга

Д.Энхтайван

Байгаль орчны газрын дарга

Б.Тогтохбаяр

"Баян-Айраг Эксплорейшн" ХХК-ний
Орон нутгийн төлөөлөгч

Ж.Жамсран

"Шувуун-Уул" ХХК-ний захирал

Л.Галднаа

"Монголын байгаль орчныг хамгаалах
холбоо"-ны Завхан аймаг дахь салбар
зөвлөлийн дарга

Э.Сайнзаяа

"Ногоон тэс" Төрийн бус байгууллагын
тэргүүн

Нарийн бичгийн

дарга

Б.Цэрэнханд

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлогын хэлтсийн
мэргэжилтэн

2. Ажлын хэсгийн ахлагч /Б.Нямдорж/-д үүрэг болгох нь:


2.1 Ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа компани болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжээс орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс, ногдол ашиг, торгууль, хандив, тусламж зэрэг орлогын тайланг аудит хийгдсэн санхүүгийн тоо, баримтад үндэслэсэн мэдээ тайланг гаргаж, олон нийтэд мэдээллэх ажлыг хэвшүүлэх

2.2 Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий компанийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, тэдгээрт оруулсан өөрчлөлт, байгаль хамгаалах талаар суманд хийсэн ажлын тайлан болон бусад холбогдох үйл ажиллагааг аж ахуйн нэгж бүрээр гаргаж дэд зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн, нийтэд ил тод мэдээллэх

2.3 Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар байгуулсан гэрээ, түүний хэрэгжилтийг олон нийтэд мэдээллэж байх.

3. Хэрэгжүүлсэн ажлын тайланг аймгийн Засаг даргад хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг дэд зөвлөл /Б.Нямдорж/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ЖАМЪЯНТИВ